

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/38/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК
Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/91.
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЫТ
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Ж.ГОМБОСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/208 дугаар тушаалын дагуу 21,500.0 мянган төгрөгийн УАЗ-220692-03 маркийн автомашин акталж, санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөр 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

G/Архив/Албан бичиг 2023/ А4

19020150

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>709,182.00</u>	<u>28,000.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	709,182.00	28,000.00
354	Хангамжийн материал	709,182.00	28,000.00
35410	Бичиг хэргийн материал	51,000.00	
35420	Аж ахуйн материал	28,000.00	28,000.00
35440	Түлш, шатах тослох материал	630,182.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,978,809.56</u>	<u>334,018.69</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,978,809.56	334,018.69
392	Биет хөрөнгө	26,813,809.55	242,352.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,490,000.00	1,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,056,666.69)	(1,990,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,795,286.00	1,795,286.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,047,250.26)	(1,795,286.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,065,218.20	20,065,218.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,432,777.70)	(19,822,866.20)
393	Биет бус хөрөнгө	165,000.01	91,666.69
39301	Программ хангамж	220,000.00	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(54,999.99)	(128,333.31)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>27,687,991.56</u>	<u>362,018.69</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>27,687,991.56</u>	<u>362,018.69</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	27,687,991.56	362,018.69
512	Хуримтлагдсан үр дүн	27,687,991.56	362,018.69
51210	Өмнөх үеийн үр дүн	47,405,687.36	27,687,991.56
51220	Тайлант үеийн үр дүн	-19,717,695.80	(27,325,972.87)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>27,687,991.56</u>	<u>362,018.69</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	47,153,600.00	64,295,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	47,153,600.00	64,295,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,153,600.00	64,295,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,153,600.00	64,295,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	65,095,640.26	77,646,672.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,095,640.26	77,646,672.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,780,133.87	72,764,598.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,110,952.61	43,690,779.08
210101	Үндсэн цалин	33,899,516.73	42,106,760.26
210102	Нэмэгдэл	211,435.88	1,584,018.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,668,695.30	5,728,689.43
210201	Тэтгэврийн даатгал	3,256,416.57	3,897,580.86
210202	Тэтгэмжийн даатгал	314,005.46	458,831.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	289,687.55	343,577.19
210204	Ажилгүйдлийн даатгал	109,144.35	89,149.13
210205	Эрүүл мэндийн даатгал	699,441.37	939,550.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	593,445.70	1,575,957.10
210301	Гэрэл, цахилгаан	80,900.70	210,832.10
210302	Түлш, халаалт	512,545.00	1,365,125.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,474,982.78	5,820,682.00
210401	Бичиг хэрэг	627,000.00	388,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,889,818.00	4,987,182.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	442,000.00	445,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	418,200.00	-
210408	Бараа материал акталсны зардал	6,097,964.78	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,791,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,791,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,279,000.00	475,000.00
210702	Дотоод албан томилолт	1,279,000.00	475,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	(91,000.00)	303,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	92,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,000.00	98,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	55,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	49,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	253,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,953,057.48	12,669,790.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,953,057.48	12,669,790.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,315,506.39	4,882,074.39
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,315,506.39	4,882,074.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,315,506.39	4,882,074.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(17,942,040.26)	(13,350,972.80)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	13,975,000.07
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	13,975,000.07
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(13,975,000.07)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(17,942,040.26)	(27,325,972.87)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	47,153,600.00	64,295,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	47,153,600.00	64,295,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,153,600.00	64,295,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,153,600.00	64,295,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	47,153,600.00	64,295,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,153,600.00	64,295,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,838,093.61	59,413,625.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,098,747.91	43,690,779.08
210101	Үндсэн цалин	33,388,606.92	42,106,760.26
210102	Нэмэгдэл	710,140.99	1,584,018.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,680,900.00	5,728,689.43
210201	Тэтгэврийн даатгал	3,294,000.00	3,897,580.86
210202	Тэтгэмжийн даатгал	346,700.00	458,831.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	277,400.00	343,577.19
210204	Ажилгүйдлийн даатгал	103,632.74	89,149.13
210205	Эрүүл мэндийн даатгал	659,167.26	939,550.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	593,445.70	1,575,957.10
210301	Гэрэл, цахилгаан	80,900.70	210,832.10
210302	Түлш, халаалт	512,545.00	1,365,125.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,990,000.00	5,139,500.00
210401	Бичиг хэрэг	678,000.00	337,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,520,000.00	4,357,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	442,000.00	445,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	350,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,026,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	1,026,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,279,000.00	475,000.00
210702	Дотоод албан томилолт	1,279,000.00	475,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	170,000.00	303,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,000.00	98,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	55,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	49,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,315,506.39	4,882,074.39
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,315,506.39	4,882,074.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,315,506.39	4,882,074.39
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			27,687,991.56	27,687,991.56
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	27,687,991.56	27,687,991.56
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
7	Тайлант үеийн үр дүн			-	-
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	27,687,991.56	27,687,991.56
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	27,687,991.56	27,687,991.56
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	27,687,991.56	27,687,991.56
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
16	Тайлант үеийн үр дүн			(27,325,972.87)	(27,325,972.87)
17	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	362,018.69	362,018.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,295,700.00	59,413,625.61	4,882,074.39	92.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,295,700.00	59,413,625.61	4,882,074.39	92.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,295,700.00	59,413,625.61	4,882,074.39	92.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,407,800.00	43,690,779.08	2,717,020.92	94.15
210101	Үндсэн цалин	43,414,800.00	42,106,760.26	1,308,039.74	96.99
210102	Нэмэгдэл	2,993,000.00	1,584,018.82	1,408,981.18	52.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,265,100.00	5,728,689.43	536,410.57	91.44
210201	Тэтгэврийн даатгал	4,408,700.00	3,897,580.86	511,119.14	88.41
210202	Тэтгэмжийн даатгал	464,100.00	458,831.74	5,268.26	98.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	371,300.00	343,577.19	27,722.81	92.53
210204	Ажилгүйдлийн даатгал	92,800.00	89,149.13	3,650.87	96.07
210205	Эрүүл мэндийн даатгал	928,200.00	939,550.51	(11,350.51)	101.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,953,500.00	1,575,957.10	1,377,542.90	53.36
210301	Гэрэл, цахилгаан	815,100.00	210,832.10	604,267.90	25.87
210302	Түлш, халаалт	2,138,400.00	1,365,125.00	773,275.00	63.84
2104	Хангамж, бараа материалын зардал	5,142,100.00	5,139,500.00	2,600.00	99.95
210401	Бичиг хэрэг	337,500.00	337,500.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	4,359,600.00	4,357,000.00	2,600.00	99.94
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	445,000.00	445,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	675,000.00	475,000.00	200,000.00	70.37
210702	Дотоод албан томилолт	675,000.00	475,000.00	200,000.00	70.37
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	352,200.00	303,700.00	48,500.00	86.23
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	146,600.00	98,100.00	48,500.00	66.92
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,900.00	55,900.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,700.00	49,700.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,295,700.00	64,295,700.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,295,700.00	64,295,700.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	64,295,700.00	64,295,700.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	5.00	5.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн анги нь эрхэм зорилгоо “Ойн баялгийн нөөцийг тогтоож хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн аж ахуйн арга хэмжээг явуулах тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Ойн тухай хууль, Ой хээрийг түймрээс хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,326.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	709.2	28.0	(681.2)
Үндсэн хөрөнгө	26,978.8	334.0	(26,644.8)
Нийт хөрөнгийн дүн	27,688.0	362.0	(27,326.0)
Өглөг	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	27,688.0	362.0	(27,326.0)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	27,688.0	362.0	(27,326.0)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 681.2 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг, түлш шатах тослох материалын үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс буурснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 26,644.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/208 дугаар тушаалын дагуу 21,500.0 мянган төгрөгийн УАЗ-220692-03 маркийн автомашин акталснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 64,295.7 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 64,295.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 64,295.7 төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 59,413.6 мянган төгрөгийг зарцуулж, 4,882.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 59,413.6 мянган төгрөг буюу 92,4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 2,717.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 1,377.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 2.6 мянган төгрөг, томилолт зочны зардал 200.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 48.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71403-Ойжуулалт				
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	64,295.7	59,413.6	4,882.1	92.4
Дүн		64,295.7	59,413.6	4,882.1	92.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сум дундын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 23/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 64,295.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 964.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 723.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 2,717.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 1,377.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 2.6 мянган төгрөг, томилолт зочны зардал 200.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 48.5 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 165 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 165 мэдээллээс 164 мэдээллийг хугацаандаа, 1 мэдээллийг хугацаа хоцроосон нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийн давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 287.2 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 287.2 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарч байна. Хэрэгжилт 66,7 хувьтай.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Төлбөрийн акт	1	287.2	1	287.2	100.0
Зөвлөмж	1	-	-	-	0.0
Нийт дүн	3	287.2	2	287.2	66.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 261.7 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 261.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчил илрээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны цалингийн зардлыг анхан шатны баримт, НДШ төлөлтийн тайлантай тулгахад ажил олгогчоос төлөх 261.7 мянган төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацааны цалингийн зардлыг анхан шатны баримт, НДШ төлөлтийн тайлантай тулгахад ажил олгогчоос төлөх 261.7 мянган төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан	1	261.7	-	-	-	-	1	261.7	-	-	-	-
Дүн	1	261.7	-	-	-	-	1	261.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>									
Шилэн дансанд мэдээлбэл зохих 165 мэдээллээс 164 мэдээллийг хугацаандаа, 1 мэдээллийг хугацаа хоцроосон	1	-	-	-	1	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn